

Жилээс жилд цаг уурын о



орчлолт улам улмаар мэдрэгдэж зундаа гандуу, оволдоо хэт хүйтрэх нь элбэгшив. Тэр дундаа алслагдсан баруун бүс нутагт гэдэг утгаараа Ховд аймагт маань хүн амын нягтрал тодий их биш ч байгаль орчин, газар дэлхийн “доройтол” таагвй үзэгдэл бусад хүн ам товлорсон томоохон суурин бүхий газраас ялгалтгүй болсон нь сэтгэл эмзэглүүлнэ.

“Газрын гарц гандуу, гадаах мал зутруу” гэдэг үгийг хэлэхээс ч цэрэвдэг байсан овгодийн үг одгоо жирийн л нэгний хэлэх үг, хийсэн үйлдэлийн бодит жишээ болсоор.

Бусад аймгуудтай харьцуулахад цөлжилт хамгийн ихээр явагдаж буй аймгуудын тоонд Ховд аймаг зүй ёсоор орох болсон. Гэтэл хэлэх, анхааруулахаас оороор хийж, сэргээж байгаа зүйлс тийм ч хангалттай биш юм шиг. Гарын хуруунд багтахар хэдхэн ажлуудыг л дурдах байх. Тор засгийн бодлого толовлогоонд тусгагдсан зүйлсийг харахад ашиглах, олборлох гэх нь нохон сэргээх, ургамлжуулах, хамгаалж тордох гэхээсээ хувь илүү. Тухайлбал ашигт малтмал, уул уурхайн олборлолтын болон томоохон үйлдвэрлэлийн тосол хэрэгжлээ гэхэд байгаль орчинд нолоолох байдлыг нь судлах, үнэлэх, толовлогоо гаргаж хэрэгжүүлэх тал нь байнга хоцроно. Судлаад толовлогоо гаргалаа гэхэд түүнд чиглэгдсэн хоронго монгийг нь гаргаж огохгүй. Чоно харайхын УЦС гэхэд л байгаль орчныг нь хамгаалах толовлогоог хийсэн морт хэрэгжүүлэх хоронгийг нь Засгийн газраас гаргаж оголгүй очноон олон жил болсныг мэргэжлийн хүмүүс ярьсаар ирсэн. Манайдаа саалийн үнээ гэгдэж буй Хошоотийн уурхайд үйл ажилагаа явуулж буй Мо Эн Ко компани ч бас л уурхайн ашиглалт, олборлолтын шатны байгаль орчинд нолоолох үнэлгээг хийлгэх, хамгаалах толовлогоог хэрэгжүүлэх тухайд хойргодуу хандсаар ирсэн. Ер нь энэ мэт уурхай ч юм уу үйлдвэрлэлийн тослийг хийхийн тулд эхлээд байгаль орчинд хэрхэн нолоолохийг нь судалж, үнэлгээ огдог байж болохгүй гэж үү? Түүнээс гадна ойжуулалт цэцэгжүүлэлт ногоон зурвас хэмээн яригдах боловч, яг цожиж байгаа, сэвэл цөлжилт үүсэх магадлал ихтэй газрыг нэг бүрчлэн судлаж тогтоосон, түүнийхээ дагуу бодлоготойгоор цаг хугацаатай орсож арга хэмжээ авч чадаж буй эсэх нь

эргэлзээтэй юм шиг санагддаг. Аймгийн тов, сум сууринд хашаа, гудамжинд ганц нэгээр мод тарина. Тарихаас ч яахав. Харин ходоо зэлүүд тал хээр нутаг, тэрхүү байгалийн унаган торхийг хадгалан үлдэх онгон зэлүүд нутгийг авч үлдэх, бий болгоход анхаарч байгаа нь аль хэр вэ?

Гэхдээ цолжилттэй тэмцэх гэдгийг зовхон мод тарихаар хязгаарлаж болохгүй. Бидний алхам тутамд цолжилт үүсгэх шалтаг шалтгаан ундарч байна. Бид тог цахилгааныг хэтэрхий ихээр замбараагүй хэрэглэх, усыг хэтэрхий гамгүй ашиглах, хэмнэлтгүй урсгах, бохирдуулах, байгаль орчинд хоноолтэй янз бвийн хэрэгсэлийг ихээр хэрэглэх зэрэгтээ алхам тутамдаа анхаарч, ядахдаа амьдралын зов дадал хэвшилтэй байх нь цолжилттэй тэмцэх бас нэг гол арга зам юм. Захын л албан байгууллагын ариун цэврийн ороонд ороход карант болон нойлын суултуураас ус нь хоржигнон гоожиж л байх жишээтэй. Тэгээд дээр нь гэгээн цагаан одроор гэрэл асаалттай. Энэ байдал орон сууцны айл орхүүдэд бас давтагдана. Тэр бүрт хичнээн хэмжээний эрчим хүч зарцуулагдаж, хэдий хэмжээний цэвэр ус хий дэмий урсаж бохирын системд орж байгаа бол. Ховд аймгийн хувьд ус цэвэрлэх байгууламж сүүлийн жилүүдээс ачааллаа даахаа больж хальж урсах нь бишгүй их болсон.

Бид байгаль, дэлхийтэйгээ гэхээс илүүтэй энгийнээр ойлговол оороо оортэйгоо, ирээдүй хойчистойгоо хэтэрхий хүнлэг бус харьцаж байна уу даа. Байгалийн нооц, баялаг ч гэсэн шавхагдах нооц. Харин хүний шунал хүсэл л шавхагдахгүй хяслан юм. Оноодор Ховдчуудын хувьд байгалийнхаа баялгийг ашиглахаас оороор аймаг орон нутаг, иргэдийн амьдралыг дээшлүүлэх нооц боломж бий. Үгүй гэхэд чацаргана тариалж түүнийгээ үр ашигтай үйлдвэрлэл болгоход л ямар их ашиг олж болохыг манай сонины омнох дугааруудад гарсан ярилцлагуудад дурдагдсан байгаа. Жишээ нь, Чацарганаас гарах 1 гр никтины хүчил 26 мянган юаньтай тэнцэнэ. 1 тн чацарганаас 7.5 гр никтины хүчил авдаг. Тэгэхээр 1 тн чацарганы шүүсийг аваад вээхээр 35-32 сая тогрогийн оорийн ортог шингээж байх жишээтэй. Чацарганаас 78 хувь нь шүүс гарч, 22 хувь нь хар үр гардаг байна. Бас францад чацарганы хальсаар фудрны баяжуулагч хийдэг богоод хальсандаа оороо Е витаминтай байдаг аж. Тэгэхээр чацарганад хүний бие махьодийг залуужуулуулах үйлчилгээтэй бодис байна гэсэн үг. Бас америкийн технологиор хар үрийг наранцэцэг шиг шахаад тосыг нь шахаж гаргадаг. Тиймээс бид хар үр, хальсаар нь хоёр тусдаа бүтээгдэхүүн гаргавал нооц боломж байгаа юм. Ховдод ердоо 200 га газар чацаргана тариад түүнийг аймгийнхаа 70 мянган хүнд хуваавал нэг хүнд 15 мянган ам.долларын орлого хүртээх боломжтой. Мон чацарганы үр, хальсаар үхэр тэжээвэл сүү нь отгордог. Хүний биед цэвэр амин дэм болох тэр их микро элемент идсэн үхрийн сүү тэр чигээрээ эм байх жишээтэй.

Энэ мэтчилэн бид байгалиа сэндийлж уул уурхай руу хэтэрхий түрэн орохоосоо урьдаар байгаль орчиноо эрүүлээр авч үлдэх, ард иргэдийнхээ амьдралыг бодитоор дээшлүүлэхэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагааг шаргуу дэмжиж, сайн үйлс, гэгээлэг зүйлсийн жишээ болгон иргэн бүхний ой тоонд суулгаж огвол бидний ирээдүй тэр чинээгээр гэрэл гэгээнд ойртож, цолжилт хэмээн хий дэмий амны уншлага болгох, айдас хүйдэст автахын аюулаас гэтлэх зам бага багаар ч гэлээ нээгдэнэ гэсэн үг.

Ховд аймгийг нэн хүчтэй цолжилтийн бүс хэмээн судалгаагаар тогтоосон богоод улс орон даяар цолжилт жил ирэх тусам осч байгаа. Тухайлбал, цолжилт жил тутамд 0.6 хувиар нэмэгдэж байгаа дүн мэдээ бий. Швейцарийн хогжлийн агентлагаас баруун бүсийн аймгууд нэг хүнд ногдох орлогоороо их доогуур байна гэдгийг судалгаагаар тогтоосон байсан. Хэрэв бид яг энэ байдлаараа урагшилбал онгон дагшин байгаль

Яг одоо зогс - цөлжилт дэргэдvүр чинь урагшилж байна ...

Бичсэн Delgerbayar

2011 оны 6-р сарын 18, Бямба гариг, 18:46

дэлхий маань оргvй хоосон тал нутаг болж, оройгоосоо цайх ондор сvрлэг уулс маань цагаан дуулгаа тайлж, тал хондий нутаг нь усгvй ангахад ойрхон байгаа билээ.